



Есөнбулаг сумын Ардчилсан намын хорооны
2020 оны 06 дугаар сарын 25-ы өдрийн
дугаар тогтоолын хавсралт

**“ЕСӨНБУЛАГ СУМЫН ӨРХ - ХӨГЖЛИЙН БОДЛОГО 2020”
МӨРИЙН ХӨТӨЛБӨР 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ**

Бид Есөнбулаг сумын өрх бүрийг орлоготой, аз жаргалтай, аюулгүй, амар тайван амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх үүднээс “ЕСӨНБУЛАГ СУМЫН ӨРХ-ХӨГЖЛИЙН БОДЛОГО 2020” мөрийн хөтөлбөр, “ИРГЭН БҮРД БОЛОМЖ, ӨРХ БҮРД ӨСӨЛТ” уриатайгаар оролцох болно.

НЭГ. ЕСӨНБУЛАГ СУМЫН ИРГЭНИЙ ХӨГЖИЛ, ӨРХ ЧӨЛӨӨ

1.1. Өрсөлдөх чадвартай боловсрол

Өнөөгийн нөхцөл байдал


Бидний шийдвэр

- Боловсролын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, 12 байраас 5 байр руу урагшуулна.
- Боловсролын салбарын багш, ажилтануудыг эрүүл мэндийн иж бүрэн урьдчлан сэргийлэх үзлэгт жил бүр бүрэн хамруулах бодлогыг баримтлана.
- Сумын сургуулийн суралцагсын дундаж оноог улсын хэмжээнд хүргэх “Боловсролын чанарын ялгааг арилгах орон нутгийн хөтөлбөр”, Сайн багш-Сайн шавь” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Багш нарыг нарын боловсролын зэрэг, чадварыг дээшлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулахыг дэмжин ажиллана.
- Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, аймаг сумынхаа байгаль, түүх, хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг сэргээн хэрэгжүүлж, “Засагт ханы хот айл” зуслан хөтөлбөрийг сэргээн үргэлжлүүлнэ.
- Малчин өрхийн 6-8 настай хүүхдийг гэрээр сургах гэрийн сургалтын тогтолцоог бүрдүүлнэ.
- Солонго хороололын дэд бүтэцийг түшиглэн 120 айлын орон сууцыг барьж ашиглалтанд оруулж, урьдчилгаагүй нэн хөнгөлөлттэй зээл болон түрээсийн нөхцөлөөр багш наарт олгох боломжийг бүрдүүлнэ.
- Тусгай хэрэгцээт (хөгжлийн бэрхшээлтэй) хүүхэдтэй ажиллах багш мэргэжилтэнг бэлтгэн, цэцэрлэг, сургуульд тусгай хэрэгцээт хүүхдийг хамруулах боломжийг бүрдүүлнэ.
- Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн, тогтвортой, улс төрөөс хараат бус байх нөхцөлийг бүрдүүлж, удирдах албан тушаалтныг чөлөөлөх, томилох асуудалд аймаг, сумдын иргэдийн төлөөллөөс бүрдсэн “Боловсролын зөвлөл”-ийн саналыг харгалздаг болгоно.
- Сургууль бүрийг интернет орчинд суурилсан “ЦАХИМ НӨМ”-ын сантай болгох ажлыг эхлүүлнэ.
- Эцэг, эх, асран хамгаалагчид багшаа сонгох боломжийг олгож, хувьсах зардлыг санхүүжүүлэх тогтолцоонд шинэчлэл хийнэ.
- Сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт заал, бассейн, хүүхдийн хөгжлийн төвийн барилга байгууламжид тавигдах нэгдсэн стандарт шаардлагыг шинэчлэн тогтоож, мөрдүүлнэ. Барилга байгууламж бүхэнд тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан зам, шат бүхий хэрэгсэлтэй болоход дэмжлэг үзүүлнэ.
- “Англи хэлийг- Алтайдаа” хөтөлбөрийг сэргээн хэрэгжүүлж, боловсролын хоёр дахь хэлний түвшинд хүргэж, бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт оруулах ажлыг эхлүүлнэ.
- АУШИС-ийн харьяа анагаах ухааны сургуулийг түшиглэн судалгааны төв, лабораториудтай болоход хамтран ажиллана.

1.2. Эрүүл иргэнтэй Есөнбулаг сум

Бидний шийдвэр.

- Хүнийг өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог өрх гэрийн түвшинд тогтолцоог хийдэг эрүүл мэндийн үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгож, гэрийн эмчийн тогтолцоог шинээр бий болгоно
- Нийтийн биеийн тамир болон чийрэгжүүлэх хөтөлбөр боловсруулан, иргэдийн санаачлага, нэгдэл, албан, албан бус бүлгийг дэмжин ажиллана.
- Солонго хороололын дэд бүтэцийг түшиглэн 120 айлын орон сууцыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтанд оруулан эмч, эмнэлэгийн байгууллагын ажилчдад урьдчилгаагүй, нэн хөнгөлөлттэй зээл болон түрээсийн нөхцөлөөр олгох боломжийг бүрдүүлнэ



ДЮА/060 9018301

- 0-5 настай хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Өрхийн эрүүл мэндийн төвийн залуу эмч нарын мэргэжил, боловсролыг тасралтгүй дээшлүүлэхэд анхаарна.
- Иргэн бүрийг насны бүлэгт нь тохирсон урьдчлан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулна.
- Уламжлалт анагаах ухааны эмнэлэгт сууринж, уламжлалт эмчилгээ, үйлчилгээний брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд бодлогоор дэмжлэг үзүүлнэ.

1.3. ӨНӨР БҮЛТЭЙ ЕСӨНБУЛАГ СУМ

1.3.1. Өрх гэр бүл

Бидний шийдэл

- Сумын иргэдийг зээлийн хөнгөлөлттэй нөхцөлөөр хувийн орон сууцтай болгох дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Хүүхэд гэр бүлийнхээ орчинд, ээж аавтайгаа хамт хүмүүжиж, төлөвших хөтөлбөр, заах аргыг хөгжүүлнэ.
- Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг сэргээн хэрэгжүүлж, хамрах хүрээг өргөжүүлнэ.
- Гэр бүлийн гишүүн бурд санхүү, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
- Өрхийн бизнес, санхүүг дэмжсэн хөтөлбөрийг боловсруулж, орон нутгийн “ЗАСАГТ ХАНЫ ГАЛ ГОЛОМТ” зээлийн санг бүрдүүлнэ.
- Солонго хороололын дэд бүтцийг түшиглэсэн 120 айлын орон сууцыг барьж ашиглалтанд оруулж залуу гэр бүл, гэр хорооллын айл өрхүүд, бусад зорилтот бүлгийн иргэдэд урьдчилгаагүй нэн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгоно.
- Гэр бүлийн бат бэх байдлыг дэмжих зорилгоор “ГЭР БУЛИЙН ӨДӨР”-ийг бий болгоно.
- Гэр бүлийн хүчирхийлэл, ялгаварлан гадуурхал, бэлгийн дарамтыг арилгах санаачилга, манлайллыг дэмжинэ.
- Хот байгуулалт, барилга, нийгэм, соёлын байгууламжийн төлөвлөлтөд нийт иргэдэд хүртээмжтэй дэд бүтцийг бий болгоно.

1.3.2. Ажлын байр хөдөлмөр эрхлэлт

Бидний шийдэл

- Гарааны бизнес буюу старт-ап залуучуудын гарааны бизнесийг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, 50 сая хүртэлх төгрөгийн санхүүжилтээр 30 ажлын байрыг шинээр бий болгоно.

1.3.3. Нийгмийн хамгаалал


Бидний шийдэл

- Ахмадын зуны сувилалыг бий болгож хөгжүүлнэ.
- Нийгмийн халамжийн салбарт сайн дурын ажлыг дэмжих, урамшуулах тогтолцоог бүрдүүлэн, давхар ажил эрхлэх боломжийг бүрдүүлнэ.
- Малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхэд бүхий гэр бүлийг хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлнэ.
- Өрх толгойлсон эцэг, эхчүүдэд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ.
- Хамтын тэтгэвэр хуулийн дагуу ахмадуудыг тэтгэвэрийн тогтолцоонд тэгш хамруулна.
- Олон давхрагат тэтгэвэрийн тогтолцоог бүрдүүлж, тэтгэвэр авагчдын орлогыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

1.3.4. Соёл, урлаг, спорт

Бидний шийдэл

- Аймгийн байгаль болон түүхийн онцлогийг харуулсан кино, тайз, дэлгэцийн бүтээлийн тоог нэмэгдүүлнэ.
- Алтай хотод музейн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна.
- “АВАРГЫГ АЛТАЙДАА” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн, спортын төрөлжсөн сургуулийг байгуулж, олимп, дэлхийн аварыг аймагтаа бэлтгэх боломжийг бүрдүүлнэ.
- Чөлөөт цагийн үйлчилгээ үзүүлэх багтаамж ихтэй байгууламж, дэд бүтцийг бий болгох төслүүдийг төр, хувийн хэвшилийн түншлэлээр хэрэгжүүлнэ.



- Аймгийн төвийн баг бурт хямд өртөг бүхий нийтийн биеийн тамирын заалыг аймгийн төсөв болон хувийн хэвшлийн оролцоотойгоор барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.

ХОЁР. ЕСӨНБУЛАГ СУМЫН ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

2.1. Жижиг дунд бизнес

Бидний шийдвэр

- Орон нутгийн онцлогт тохирсон бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсруулж, ЖДҮ-ийг бий болгох орон нутгийн бодлого боловсруулж ажиллана.
- Бизнест учирдаг авилгын дарамтыг арилгах чиглэлд хүчтэй ажиллана. Технологийн дэвшлийг ашиглан авилгыг мэдээлэх, илрүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- Бүртгэл, хяналт, лавлагаа, мэдээлэл, худалдан авах ажиллагаа зэрэг төрөөс авах бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ.
- Төрийн зүгээс бизнес эрхлэгчдэд үзүүлж буй хүнд суртал, дарамтыг арилгаж, татвар төлөгч аж ахуйн нэгжүүдээ үйлчилдэг, зөвлөдөг тогтолцоог бий болгоно.
- “Алтайд үйлдвэрлэв” брэндийг хөгжүүлж нутгийн ЖДҮ эрхлэгчдийн борлуулалт, маркетингийг дэмжсэн интернэт худалдааны сүлжээг үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдтэй хамтран байгуулна.
- Алтай хотын худалдаа үйлдвэрлэл хувиараа эрхлэгчдийн ажиллах орчныг сайжруулах ажлыг хувийн хэвшлийн түншлэлээр хийх боломжийг бүрдүүлнэ.

2.2. Хөдөлмөрийн зах зээл

Бидний шийдвэр

- Төрийн албанаас бизнесийн салбарт шилжин баялаг бүтээх иргэдээ эдийн засгийн бодлогоор дэмжиж, орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

2.3. Дэд бүтэц

Бидний шийдвэр

- Есөнбулаг сумд “АРДЧИЛАЛЫН ГУДАМЖ” төслийг (Хүрэл морьтой хөшөөний уулзвараас Шинэ Алтай захын урд уулзвар хүртэл) хэрэгжүүлж, орчин үеийн хотын стандартад нийцсэн, ус зайлцуулах инженерийн шугам бүхий бүтээн байгуулалтыг хийж гүйцэтгэнэ.
- Хүүхэд залуусын чөлөөт цагийг зөв өнгөрөөх зорилго бүхий “АЛТАЙ ГЭРЭЛТ ГУДАМЖ”-ийг бий болгох ажлыг дэмжин ажиллана.
- Есөнбулаг сумын Жаргалант, Түмэн багт олон улсын байгууллага хувийн хэвшлийн оролцоотойгоор хөрсний бохирдолыг бууруулах зорилго бүхий эрүүл ахуйн шаардлагад нийцсэн “АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэнлэ.
- Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэлийн бүсэд “ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БҮС”-ийг шинээр байгуулах ажлыг хувийн хэвшлийн түншлэлээр эхлүүлнэ.
- Солонго хороололын дэд бүтцийг түшиглэн хямд өртөг бүхий, гадна тохижолтыг бүрэн шийдсэн орчин үеийн стандартад нийцсэн амины орон сууцны хороололыг барих ажлыг хувийн хэвшлийн түншлэлээр эхлүүлнэ.
- Есөнбулаг сумд “ХӨГЖЛИЙН ГУДАМЖ” төслийг (Нисэхээс Морь барианы газар) хэрэгжүүлж, Алтай хотыг орчин үеийн хот болгох суурийг эхлүүлнэ.
- Төвлөрсөн шугам сүлжээнд холбох боломжтой Баянхайрхан, Харзат, Түмэн, Жаргалант багийг түшиглэн орчин үеийн хувийн байшин хороолол бүхий “ХАШААНДАА САЙХАН АМЬДРАЯ” жишиг төслийг хэрэгжүүлнэ.
- Есөнбулаг сумын хүүхдийн паркийг түшиглэн орон нутгийн соёл амралт, цэцэрлэгт хүрээлэнгийн “МАЗААЛАЙ” цогцолборыг дахин төлөвлөж, ашиглалтанд оруулна.
- Орон нутгийн авто замын сүлжээг үргэлжлүүлэн сайжруулна.
- Авто зам ашигласны төлбөр хураах орон нутгийн бодлогыг боловсруулж, зам арчилгааны асуудлыг шийднэ.
- Алтай хотод баригдах дулааны станцыг ашиглалтанд оруулж, шугам сүлжээг бүрэн шинэчилэн хэрэглээний халуун, хүйтэн устай болгоно.
- МХГазрын хуучин барилгыг ашиглан ЖДҮ-ийг дэмжих төв болгон хөгжүүлж, шинээр бизнес эрхэлж байгаа залуучуудыг ажлын байраар хангана.
- Хуучин номын сангийн барилгыг ашиглан “БАГШ ХӨГЖЛИЙН ТӨВ”-ийг шинээр байгуулж, шинэ, ахмад багш нарын эргэх уялдаа холбоо бүхий харилцааг бий болгоно.
- 6-р цэцэрлэгийн хуучин барилгыг ашиглан “ИРГЭНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ”-ийг шинээр байгуулна.
- Алтай хотын цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг сайжруулж, цэвэрлэгээний чанарыг нэмэгдүүлэн өргөтгөнө.

6217144719
ДЮА0066 9018301

- Ашиглалтын хугацаа дууссан болон солих шаардлагатай цэвэр ус болон ариутгах татуургын шугамыг шинэчлэн солино.
- Зөөврийн усан хангамжийг төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлнэ.
- Үндны хэрэглээний цэвэр усны шугам сүлжээг шинээр төлөвлөж, 2-р хэлхээний шугамыг хийх ажлыг судалж эхлүүлнэ.
- Ус хангамжийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийг шинэчлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана.
- Жаргалан сум Завхан голд орон нутгийн чанартай гүүр барихад дэмжлэг үзүүлэн ажиллана.

2.4. Эрчим хүч

Бидний шийдэл

- Алтай хотод Азийн Хөгжлийн банкны санхүүжилтээр 10 МВт-ын нарын цахилгаан станц ашиглалтанд оруулна.
- Цахилгаан эрчим хүчиний үнэ тарифын загварыг боловсронгуй болгон зах зээлийн зарчимд тулгуурласан, хэрэглэгчдэд ээлтэй уян хатан систем нэвтрүүлнэ.
- Шинэ зууны малчин хөтөлбөр хэрэгжүүлж малчин өрхүүдийг хүчин чадал өндөртэй цахилгаан хэрэгсэл ашиглах боломжоор хангаж, бодлогоор дэмжинэ.
- Алтай хотын шинэ суурьшилын бүсэд агаарын цахилгаан дамжуулах 13 Кв-ын шугам шинээр байгуулна.

2.5. Шинжлэх ухаан, технологи, мэдээлэл, харилцаа

- Орон нутагт өндөр хурдны интернэтийн сүлжээг өргөтгөж, 5G технологийг нэвтрүүлнэ.
- Багш нарын цахим боловсролын ур чадварыг сайжруулах хөтөлбөрийг аймгийн хэмжээнд боловсруулж хэрэгжүүлнэ.

2.6. Барилгын салбар

- Чулууны үйлдвэрлэлийг хувийн хэвшлийн түншлэлээр барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.
- Төрийн албан хаагч, бага орлого бүхий зорилтот бүлэгт зориулсан 120 айлын орон сууцыг Солонго хороололын дэд бүтцийг түшиглэн байгуулна.

2.7. Хүнсний үйлдвэрлэл

- “Эрүүл хүнс” орон нутгийн хөтөлбөр хэрэгжүүлж, мах, сүү, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг бүрэн хангаж, эрүүл, аюулгүй байдлын баталгааг дээшлүүлнэ.
- Дөрвөн улирлын хүлэмжийн төсөл хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.
- Алтайн жимс жимсгэнэ хөтөлбөрийг боловсруулж, хувийн хэвшлийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
- Ерөнхий боловсролын сургуульд “Хүнсний тухай боловсрол” олгох орон нутгийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг төрийн бүх байгууллагууд хэрэглэдэг байх журам тогтоож, орон нутгийн бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.8. Бүтээлч үйлдвэрлэл

- Контент бизнесийг дэмжих замаар орон нутгийн онцлог, өв соёлыг сурталчлахад анхаарна.
- Орон нутгийн онцлогийг тусгасан зураг, анимэшн, манга ба бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

ГУРАВ. ЕСӨНБУЛАГ СУМЫН ЭЗЭН

3.1. Орон нутгийн хөгжил

- Сумын эдийн засгийн бие даасан байдлыг хангах, төсөв бүрдүүлэх, зарцуулах эрхийг нэмэгдүүлнэ.
- Орон нутгийн аж ахуй нэгж, компаниудын чадавх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх төслийг дэмжинэ. Мал аж ахуй, газар тариалан, гахай, тахиа, зэгийн аж ахуйд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загварыг хөгжүүлэх судалгаа, хөгжүүлэлтийн зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.
- Иргэдийн санаачлага болон хувийн хэвшлийн оролцоотойгоор иргэдэд санхүүгийн боломж олгох хоршоо, санхүүгийн байгууллагыг байгуулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.

3.1.1. “Чинээлэг малчин” хөтөлбөр

- Мал аж ахуй салбарыг эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн шинэ технологи, инновацад суурилж, хөгжүүлэн мэдлэг бүхий малчдыг малчин бизнесмен болгох замаар тогтвортой орлого бүхий хүчтэй дундаж давхаргыг тэлэх бодлого хэрэгжүүлнэ.
- Иргэдийн санаачилгад суурилсан Чинээлэг малчин хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- Малчдын орлогыг дэмжих зорилгоор малчин өрх бүр сүү боловсруулах жижиг оврын сүү боловсруулах хямд өртөг бүхий тоног төхөөрөмжөөр хангах ажлыг хувийн хэвшлийн түншлэлээр хийж гүйцэтгэнэ.

3.3 Бэлчээр ашиглалт

- Малчдын хамтын оролцоонд тулгуурлан аймгийн газар нутгийн 70 гаруй хувийг эзэлж байгаа бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийн 30-аас доошгүй хувийг сэргээнэ.
- Ямаан сүргийн зохистой харьцааг шинжлэх ухааны үндэстэй тогтооно. Ноолуур ба ноолууран бүтээгдэхүүнийг орон нутгийн хэмжээнд үйлдвэрлэх иргэд, аж ахуйн нэгжийн санаачилгыг дэмжин ажиллана.
- Малын хөлийн татварын тогтолцоог бүрдүүлж, тус орлогыг орон нутгийн төсвөөр дамжуулан бэлчээрийн нөхөн сэргээлтэд зориулна.
- Бэлчээрийн зохистой менежментийн бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Наран, Рашаант багт хөв булгийг байгуулж, шар усыг хуримтлуулан, бэлчээрийг усжуулах ажлыг эхлүүлнэ.
- Байгаль цаг уурын өөрчлөлттэй холбоотойгоор малын бэлчээрийг усжуулах, худаг шинээр гаргах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Бэлчээрийн даацад тохируулан мал сүргийн бүтцийг сайжруулах бодлогыг боловсруулж, хэрэгжилтэд манлайлан оролцож байгаа малчдыг урамшуулах журмыг бий болгоно.

3.4. Мал аж ахуй

- Малыг тооноос илүү чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид сууриссан мал аж ахуйг бодлогоор дэмжинэ.
- Махыг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулж, малыг вакцин, туулгад бүрэн хамруулан эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлнэ.
- Хөдөөгийн малчин өрхийг дэмжин “Малжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.
- Бэлчээрийн ашиглалттай холбоотойгоо сумын аварга малчныг шалгаруулах болзолыг шинэчлэн мөрдүүлж эхэлнэ.
- Мах болон сүүний чиглэлийн үржил сайтай, нутгийн онцлогт тохирох жишиг фермерийн аж ахуйг хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулах ажлыг эхлүүлнэ.
- Газар тариалангийн бүс нутгийг түшиглэн мал бордох ажлыг хувийн хэвшлийн оролцоотойгоор эхлүүлнэ.
- Ямааны үүлдэр угсааг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлснээр нэг ямаанаас гарах ноолуурын гарцыг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Алтай хотод мал аж ахуй эрхлэх боломж бүхий суурьшлийн бүсийг сэргээн “МАЛЧНЫ ХОРООЛОЛ”-ыг дахин төлөвлөж, хотын төв болон гэр хороололоос малыг бүрэн гаргах ажлыг эхлүүлнэ.

3.5. Газар тариалан

Бидний шийдэл

- “Алтайн жимс жимсгэнэ” дэд хөтөлбөрийг боловсруулж, өрх бүр жимс жимсгэнэ тариалахад бодлогоор дэмжинэ.
- Хүнсний ногоо болон үрийн нөөцийг хадгалах орчин үеийн дэвшилтэт технологид сууриссан зоорийг барихад бодлогоор дэмжин ажиллана.
- Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж буй хувь хүн, ААН-ийг урамшуулах, дэмжих бодлогыг баримтлана.

ДӨРӨВ. ХУУЛЬТАЙ ЕСӨНБУЛАГ СҮМ


Бидний шийдэл

4.1. Иргэнээ хамгаалдаг хууль

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд залуусыг гэмт хэрэгт өртөхөөс хамгаалах арга ажиллагааны хүртээмж, үр нөлөөг нэмэгдүүлэхэд онцгой анхаарна.
- Нас, хүйс, хөгжлийн ялгаа, бэлгийн чиг баримжаа гэх мэт аливаа төрлийн ялгаварлал, дарамт, хүчирхийллийг ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн үе шаттай арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.
- Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах, ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэх тогтолцоог боловсронгуй болгоход анхаарна.
- Иргэд нийтэд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхэд анхаарна.

4.2. Иргэндээ үйлчилдэг засаглал

- Сонгогдсон, томилогдсон төрийн албан тушаалтан нь ёс зүйн зөрчил гаргасан бол олон нийтээс училгыг үүрэгтэй эрх зүйн орчныг бий болгож, түүнийг огцруулах, чөлөөлөх хууль зүйн үндэслэлийг тодорхой болгоход анхааран ажиллана.



- Авлига, албан тушаалын гэмт хэрэг, хууль бус шийдвэрийн улмаас учирсан хохирлыг барагдуулах механизмыг сайжруулна.
- Төрийн албаны удирдах албан тушаалтны тоог бууруулж, дарга нарын тансаглалыг таслан зогсооно.
- Төрийн албан хаагчидтай ашиг сонирхол болон хариуцлагын гэрээг шинэчилж, жил бүр дүгнэдэг журмыг бий болгоно.
- Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэх тогтолцоог сайжруулна.
- Гэр хороололын иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор камержуулах ажлыг бүрэн хийж, иргэний хяналтын тогтолцоог бий болгоно

4.3. Иргэн нь шийддэг нийгэм

- Төрийн байгууллага, удирдах албан тушаалтан жил бүр иргэдэд ажлын тайлангийн сонсгал хийх, уулзалт хийх үүргийг хүлээнэ.
- Иргэддээ итгэж, анхан шатны нэгж дээрээ асуудлаа шийдвэрлэх зарчмыг нутгийн удирдлагад бэхжүүлэх, сайжруулахад баримталж, орон нутгийн эрх мэдэл, төсвийн боломжуудыг нэмэгдүүлнэ.
- Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, хяналт хийх болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
- Алтай хотын газар зохион байгуулалт, олголтыг иргэдийн оролцоотой, иргэдэд нээлттэй ил тод байдлаар зохион байгуулах орон нутгийн журмыг боловсруулан мөрдүүлнэ.

4.4. Хөгжлийг дэмждэг хууль

- Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажлыг бодитоор хэрэгжүүлж, үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ.
- Иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлнэ. Цахим өргөдөл, гомдолын 7048 11-11 төвийн үйл ажиллагааг сэргээнэ.
- Төрөөс зохион байгуулах аливаа төсөл, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, сонирхлын зэрчлөөс ангид, олон нийтэд ил тод болгоно.

ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН ЕСӨНБУЛАГ СУМ

Бидний шийдэл


5.1. Хүрээлэн буй орчин, ногоон хөгжил

5.1.1. Экосистемийн тэнцвэртэй байдал

- Экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалийн нөөц баялгийн зүй бус ашиглалтыг зогсоох, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг ханган, хүний амьдралын чанарыг сайжруулна.
- Усны хэрэглээ, хяналт, хэмнэлтийн бодлогыг бий болгож, менежментийг сайжруулна.
- Наран, Рашаант багт хөв цөөрөм байгуулж, усны нөөцийг хуримтлуулах замаар говь тал, хээрийн нутгыг усаар хангах чиглэлээр ажиллана.
- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэргээр цогц үйл ажиллагааг шат дараалан авч хэрэгжүүлнэ.
- Рашаан, булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулна.
- Экосистемийн тэнцвэртэй байдлыг хадгалахад үйл ажиллагаа болон өөрийн хөрөнгөөр хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- Жил бүр өрх бүр мод тарьж хэвшиүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж “Ногоон Алтай” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Алтай хотын ногоон байгууламжид эрс шинэчлэлт хийж, иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх “**НОГООН ХОТ**” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Ерөнхий боловсролын сургууль төгсөгчид болон АШУИС-ийн салбар сургуулийн төгсөгчдийн нэрэмжит “**АМЬДРАЛЫН НАХИА**” төгөлийг үүсгэн жил бүр мод тарих аяныг өрнүүлнэ.
- Цөлжилтийн эсрэг цогц арга хэмжээний хөтөлбөр боловсруулж мэргэжлийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүд, нутгийн зөвлөлүүд, иргэдтэй хамтран хэрэгжүүлнэ.

5.1.2. Байгаль орчны тогтвортой хөгжил

- Есөнбулаг сумын хэмжээнд утааг бууруулах зорилгоор сэргээгдэх эрчим хүч, шинэ техник технологийг ашиглан гэр хороололын оршин суугчдад дулаан нийлүүлэх иргэд, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.



- Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн үйл ажиллагааг шинэчилэн зохион байгуулж, иргэдэд нээлттэй, оролцоог хангасан байхаар зохион байгуулахаас гадна барилга байгууламж, хашааг шинээр барьж байгуулахад нийт эзэмшил болон өмчлөлийн талбайн 10-аас багагүй хувьд ногоон байгууламжийг хийхээр гэрээг байгуулах журмыг бий болгоно.
- Нөхөн сэргээлт хийх нэрээр хууль бусаар ашигт малтмал олборлох асуудлыг ил, далд байдлаар тусгасан аливаа гэрээ хэлцэл хийхийг таслан зогсоно.
- “Жорлонгоо өөрчилье” хөдөлгөөнийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, төв суурин газрын айл өрх бурийг эко, эрүүл ахуйн стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг зохион байгуулна.
- Хувийн мал эмнэлэг, чиглэлийн төрийн байгууллагын оролцоотойгоор Алтай хотын золбин нохой, муурын устгалын төлөвлөгөөг эрс шинэчлэн, байгаль орчинд нөлөөлөхгүй байхаар менежментийн бодлогыг боловсруулан мөрдүүлнэ.

